



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 07 өдөр

Дугаар А/125

Номгон

“Гэгээн сумади” сургууль, цэцэрлэгийн
цогцолборын автобусны зардал олгох,
аюулгүй байдлыг хангах тухай

Боловсрол, шинжлэх ухааны сайд болон аймгийн Засаг даргын хооронд 2022 онд орон нутагт боловсрол, шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах гэрээнд заасан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Сангийн сайдын 2021 оны оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 61 дүгээр тушаалаар баталсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Баянхонгор сумын Шинэ суурьшлын бүс дэх “Гэгээн сумади” сургууль, цэцэрлэгийн цогцолборын үйл ажиллагаа эхэлсэнтэй холбогдуулан сургуулийн автобус худалдан авч сурагчдыг тээвэрлэх үйлчилгээнд ажиллуулсугай.

2.Автобус худалдан авах зардлын 15.000.000 (Арван таван сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал)-д зөвшөөрсүгэй.

3.Сургуулийн автобусны техникийн бүрэн бүтэн байдалд хяналт тавьж зохих хууль тогтоомжийг мөрдүүлж ажиллахыг Баянхонгор сумын Засаг дарга (Г.Энхбаяр), Цагдаагийн газар (Б.Оюутболд) нарт тус тус үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Байгаль орчин, уул уурхай, нийгмийн салбар хариуцсан орлогч (Ж.Мөнхсоёл)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН